



ТӨСЛИЙН УРАЛДААН ЗАРЛАЖ БАЙНА

МУИС-ийн бүтцийн нэгжүүд, бүрэлдэхүүн, салбар сургуулийн тэнхимүүд хоорондын төслийн уралдааны УДИРДАМЖ



ТӨСЛИЙН ЗОРИЛГО

МУИС-ийн Стратегийн төлөвлөгөө /2016-2024/-ний Тэргүүлэх чиглэл 4.1, 4.2, 4.3, Маркетингийн төлөвлөгөө /2018/-ний хүрээнд бүтцийн нэгжүүд, бүрэлдэхүүн, салбар сургуулийн тэнхимүүд хоорондын хамтын ажиллагаа, уялдааг сайжруулах, бүтээлч санаачилгыг дэмжих, эерэг соёлыг бүрдүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн хийх ажлын санаачилгыг боловсруулах

ТӨСЛИЙН ЧИГЛЭЛ

- Ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн шинэлэг санаачилга боловсруулах, нэвтрүүлэх
- МУИС-ийн гишүүн /багш, ажилтан, суралцагч, төгсөгч/ бүрт хэвшүүлэх байгууллагын эерэг соёлын санаачилга боловсруулах, нэвтрүүлэх
- МУИС-ийн бүтцийн нэгжүүд, бүрэлдэхүүн, салбар сургуулийн тэнхимүүд хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн санаачилга боловсруулах, нэвтрүүлэх
- Санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн хийх ажлын санаачилга боловсруулах, нэвтрүүлэх

ТӨСЛИЙН ҮР ДҮН

Уралдаанд шалгарсан төслүүдийг МУИС-ийн 2019 үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах ба санаачлагч баг хамт олонтой хамтарч ажиллана.

ТӨСЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

МУИС-ийн бүтцийн нэгжүүд, бүрэлдэхүүн, салбар сургуулийн тэнхимүүдээс 3-5 хүний (багш, ажилтан, суралцагч, төгсөгч) бүрэлдэхүүнтэй баг оролцоно.

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

- Төслийн танилцуулга (3 хүртэл хуудас)
- Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө
- Төслийн төсөв
- Багийн танилцуулга /Төслийн багийн гишүүдийн нэр, утас, мэйл хаяг, нэгж, сургуулийг хүснэгтэд оруулсан файлаар/

МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ ХУГАЦАА, ХАЯГ

2018 оны 4 дүгээр сарын 9-нөөс 4 дүгээр сарын 27-ны 14.00 цаг хүртэл МУИС-ийн 1-р байр, 219 тоот

ШАЛГАРУУЛАЛТ

Шалгаруулалтыг томилогдсон бүрэлдэхвн явуулах бөгөөд дараах шалгуураар байр эзлүүлнэ.

- Судалгаа, шинжилгээ, хүрэх үр дүн
- Практик ач холбогдол
- Хэрэгжүүлэх боломж
- Санхүүгийн дүн шинжилгээ
- Үйл ажиллагааны хэтийн төлөв
- Багийн гишүүдийн үүрэг оролцоо

ШАГНАЛЫН САН

- I байр - Өргөмжлөл, дурсгалын зүйл, 500 000 төгрөг
- II байр - Өргөмжлөл, дурсгалын зүйл, 350 000 төгрөг
- III байр - Өргөмжлөл, дурсгалын зүйл, 300 000 төгрөг

Та бүхнийг уралдаанд идэвхтэй оролцож, өөрсдийн мэдлэг, чадвараа сорихыг уриалж байна.

Дэлгэрэнгүй мэдээлэл авах утас: 75754400, 77307730-1160,1162, 99018393, 99072004, ganba@num.edu.mn, ganba8899@gmail.com и-мэйлээр авна.

ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ХЭЛТЭС

2018 он